



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 16

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас  
балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь

1. Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 172,418,540 (нэг зуун далан хоёр сая дөрвөн зуун арван найман мянга таван зуун дөч) төгрөгийн балансын үнэтэй, 138,263,298.81 (нэг зуун гучин найман сая хоёр зуун жаран гурван мянга хоёр зуун ерэн найман төгрөг наян нэгэн мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй 0,4 метр цахилгааны шугам, трансформаторыг “Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХКомпанийн харъяа Говьсүмбэр аймаг дахь салбарын өмчид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Шилжүүлэх хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн  
16 тогтоолын хавсралт



Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын  
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	0,4 шугам	2015	ш	1	172,418,540	34,155,241.19	138,263,298.81	
Нийт дүн					172,418,540 (нэг зуун далан хоёр сая дөрвөн зуун арван найман мянга таван зуун дөч) төгрөг	34,155,241.19 (гучин дөрвөн сая нэг зуун тавин таван мянга хоёр зуун дөчин нэгэн төгрөг арван есөн мөнгө) төгрөг	138,263,298 (нэг зуун гучин найман сая хоёр зуун жаран гурван мянга хоёр зуун ерэн найман төгрөг наян нэгэн мөнгө) төгрөг	БЗӨБЦТС